

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ  
АЖЛЫН ТАЙЛАН

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2024 оны үйл ажиллагааны хагас жилийн тайлан  
Байгууллагын нэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв  
Огноо: 2024.06.10

№	Үйл ажиллагаа	Биелэлт /тусгах мэдээлэл/				Зарцуулсан төсөв, эх үүсвэр
1	Хуралдаан	<p>Огноо: 2024.01.17 Хэлэлцсэн асуудал: Ёс зүйн хорооны 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл. Шийдвэр: Ёс зүйн хорооны 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд гишүүдийн саналыг тусган батлуулахыг Ёс зүйн хорооны нарийн бичигт үүрэг болгов. Огноо: 2024.04.01 Хэлэлцсэн асуудал: Монгол улс Ёс зүйн хорооны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг танилцуулах, Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын төсвийг хэлэлцэх. Шийдвэр: Ёс зүйн хорооны 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа гүйцэтгэн тайлагнах, Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын төсвийг 1,500,000 төгрөгөөр тооцох.</p>				Ёс зүйн хорооны дарга болон нарийн бичгийн даргад сар бүр албан тушаалын цалингийн 20 хувь, 5 гишүүнд 10 хувийн урамшууллыг захирлын тушаалаар олгодог.
2	Ёс зүйн сургалтад хамрагдсан хүний тоо	Эмч	Эмнэлгийн мэргэжилтэн	Эмнэлгийн бусад мэргэжилтэн	Иргэд, үйлчлүүлэгч	
			290	86		
3	Ёс зүйн сургалтын сэдэв			Ажлын байрны стресс тайлах арга		
				Ёслолын сургалт		
				Төрийн албан хаагчийн ёс зүй, эрүүл мэндийн салбарын онцлог		
4	Хүлээн авсан өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэсэн байдал	Иргэн	Эмнэлгийн мэргэжилтэн	Хэсгийн хороо/ёс зүйн баг	Хяналтын хорооноос шилжүүлсэн	
		-Эвлэрүүлэн зуучилсан: - Хөдөлмөрийн хуулийн дагуу:	-	-	-	

		- Эмчлэх эрхийн зөвшөөрөл цуцлах саналтай: -Зөрчлийн мэдээний санд бүртгэсэн:				
5	Эвлэрүүлэн зуучилсан тохиолдлын тоо	Эмч, үйлчлүүлэгч хооронд	Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч хооронд	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хооронд	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, удирдлагын хооронд	
		-	-	-	-	
6	Ёс зүйн зөрчлөөс сэргийлэх чиглэлээр хийсэн ажил	Нийт ажилтан, албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар соён гэгээрүүлэх сургалтыг байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Танхимаар 3 сургалт зохион байгуулж, 57 мэдээлэл, 3 видео шторкийг дотоод сүлжээ болон ухаалаг дэлгэцээр нэвтрүүлж, 1 гарын авлага гарган шинээр ажилд орсон 5 албан хаагчдад хүргэсэн.				-
7	Шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажил	2025 оны хуанлийн эхийг бэлтгэн хэвлүүлэхэд бэлэн болгосон. Хуанлид тухайн сарын нийтийн тэмдэглэлт өдрүүд болон эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд, Дэлхийн ёс зүйн өдөр зэрэг мэдээллийг оруулсан.				-
8	Цахим хуудасны мэдээллийг баяжуулсан байдал	Цахим хуудасны Ил тод хэсэгт ёс зүйн хууль, дүрэм 5 мэдээлэл, дотоод сүлжээний ERP системд байгууллагын ёс зүйн хорооноос бэлтгэсэн 8 мэдээлэл, 1 гарын авлагыг байршуулж, нэвтрүүлсэн. Цахим хуудасны Цаг үеийн мэдээ цэсэнд Ёс зүйн хорооноос зохион байгуулсан 2 удаагийн сургалт, ярилцлагын мэдээг нийтэлсэн. Холбогдох линк: <a href="http://hdc.gov.mn/post/1306/">http://hdc.gov.mn/post/1306/</a> <a href="http://hdc.gov.mn/post/1221/">http://hdc.gov.mn/post/1221/</a> <a href="http://hdc.gov.mn/page/95/">http://hdc.gov.mn/page/95/</a> Цахим хуудсаар ирүүлсэн асуултуудад холбогдох мэргэжилтнүүд болон олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн хариултыг цаг тухайд нь өгч ажиллаж байна.				-
9	Зөрчлийн мэдээний сангийн хөтлөлт			-		-

Тайлан гаргасан: ..... (Б.Байгалмаа)

Тайланг баталгаажуулсан: ..... (Б.Болдбаатар)



ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХӨГЖЛИЙН ТӨВ

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Үйл ажиллагаа	Зорилгот төвшин	Гүйцэтгэл
<b>1. Ёс зүйн хорооны үйл ажиллагааны чиглэлээр</b>			
1	Ёс зүйн хорооны хурлыг улирал бүр товлон хуралдана.	4-өөс доошгүй удаа хурал зохион байгуулж, ажлаа дүгнэсэн байна.	Ёс зүйн хороо нь 1-р улиралд 2024.01.17-ны өдөр, 2-р улиралд 2024.04.01-ний өдрүүдэд хурлын төлөвлөгөөг батлуулан хуралдаж, холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Хурлын тоо: 2 Ирц: 100%
2	Ёс зүйн хорооны үйл ажиллагааны тайланг холбогдох байгууллагад цаг тухай бүр тайлагнана.	Тайланг хугацаанд нь гаргаж хургуулсан байна.	ЭМХТ-ийн Ёс зүйн хорооны 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гаргаж, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 1198 дугаартай албан бичгээр ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хургуулсан. Хургуулсан тайлан: 1
<b>2. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр</b>			
3	Ёс зүйн хэм хэмжээний тухай гарын авлага боловсруулж, шинэ албан хаагчдад танилцуулна.	Гарын авлага боловсруулан хэвлүүлж, албан хаагчдад олгосон байна.	Шинээр ажилд орсон 5 албан хаагчдад гарын авлагыг олгон чиглүүлэх сургалтаар холбогдох хууль, дүрэм, журмыг танилцуулсан. 
4	Ёс зүйн хуанли гаргаж албадад түгээнэ.	Хуанлийг гаргаж, албадуудад олгосон байна.	2025 оны хуанлийн эхийг бэлтгэн хэвлүүлэхэд бэлэн болгосон. Хуанлид тухайн сарын нийтийн тэмдэглэлт өдрүүд болон эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд, Дэлхийн ёс зүйн өдөр зэрэг мэдээллийг оруулсан. 



5	Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулна.	Сургалт зохион байгуулж, албан хаагчдын 60-аас доошгүй хувийг хамруулсан байна.	2024-2025 оны хичээлийн жилийн багц цагийн богино хугацааны сургалтын батлагдсан төлөвлөгөөнд сургалтыг 4-р улиралд зохион байгуулахаар орсон.
6	"Ажлын байрны стресс тайлах арга" ярилцлага зохион байгуулна.	Бүлгийн ярилцлага зохион байгуулж, албан хаагчдын 60-аас доошгүй хувийг хамруулсан байна.	 <p>2024.04.12-ны өдөр СЭМҮТ-ийн эмч магистр, Л.Эрдэнэсүвдэг урьж, ажлын байрны стресс тайлах арга сэдвээр бүлгийн ярилцлага, багийн ажлыг зохион байгууллаа. Бэлтгэж ирсэн зурагнундаас багийн гишүүнээ тодорхойлох зургийг сонгон тухайн хүний зан араншин, хандлагыг зургаар илэрхийлж тайлбарлах бүлгийн ажил явагдсан. Ярилцлагад 42 албан хаагч хамрагдаж, багаар ажиллан ярилцаж, ажлын байрны стрессээ тайлах нэгэн аргад суралцлаа.</p> 
7	"Байгууллагын соёл гэж юу вэ" сургалт нөлөөллийн ажил зохион байгуулна.	Сургалт зохион байгуулж, албан хаагчдын 60-аас доошгүй хувийг хамруулсан байна.	Хамрагдсан албан хаагчийн хувь: 58 2024-2025 оны хичээлийн жилийн багц цагийн богино хугацааны сургалтын батлагдсан төлөвлөгөөнд орсон. Сургалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулан хянуулаад байна.
8	Дэлхийн ёс зүйн өдрийг тэмдэглэн сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.	Арга хэмжээг зохион байгуулж, хаагчдын 80-аас доошгүй хувийг хамруулсан байна.	2024 оны Дэлхийн ёс зүйн өдөр 10 дугаар сарын 16-нд "Ёс зүйг хүчирхэгжүүлнэ" уриан дор болно. Энэхүү уриан дор албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, ёс зүйн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах, уриалах буюу соён гэтээрүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллана.

9	“Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” сургалт зохион байгуулна.	Сургалт зохион байгуулж, албан хаагчдын 60-аас доошгүй хувийг хамруулсан байна.	2024-2025 оны хичээлийн жилийн багц цагийн богино хугацааны сургалтын батлагдсан төлөвлөгөөнд сургалтыг 3-р улиралд зохион байгуулахаар орсон.
10	Ёслолын сургалт	Сургалт зохион байгуулж, албан хаагчдын 60-аас доошгүй хувийг хамруулсан байна	ГХЯ-ны Дипломат ёслолын газрын зөвлөхтэй хамтран Ёслолын сургалтыг 1 сарын 19-ний өдөр зохион байгуулж, 44 албан хаагч хамрагдсан. Уг сургалтаар ёслол протоколын арга хэмжээ, уулзалт хэлэлцээр зохион байгуулах арга зүй, биеэ авч явах соёл зэрэг мэдлэг мэдээлэл олгов. Хамрагдсан албан хаагчийн хувь: 60.2%
11	Төрийн албан хаагчийн ёс зүй, эрүүл мэндийн салбарын онцлог	Резидент эмч нарыг хамруулах	2024.05.07-ны өдөр төвийн ХНХА, Ёс зүйн хорооноос Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч А.Алтанзулыг урьж “Төрийн албан хаагчийн ёс зүй, эрүүл мэндийн салбарын онцлог” сургалт зохион байгууллаа. УНТЭ дээр зохион байгуулагдсан уг сургалтад 280 резидент эмч, ХНХА-ны мэргэжилтнүүд хамрагдаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Эрүүл мэндийн салбарын ёс зүйн дүрмийн онцлогийн талаар мэдлэг мэдээлэлтэй болсон. Хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн: 290

**3. Албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр**

11	Шинэ ажилтан, албан хаагчдад Эмнэлгийн болон мэргэжилтний байгууллагын ёс зүйн дүрмийг танилцуулах, ёс зүйн баталгаа гаргуулна.	Шинэ албан хаагчдаас Ёс зүйн баталгаа гаргуулсан байна.	<p>Шинээр ажилд орсон 4 албан хаагчдад чиглүүлэх сургалт зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, харилцаа хандлага, биеэ авч явах соёл, ажлын цаг ашиглалтын талаар мэдээлэл өгөв.</p> <p>Холбогдох хууль, дүрмийг танилцуулан Ёс зүйн баталгаа гаргуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль</li> <li>❖ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм</li> <li>❖ ЭМХТ-ийн ажилтан албан хаагчдын ёс зүйн дүрэм</li> <li>❖ Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл</li> </ul>
----	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------



		<p>❖ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм. Ёс зүйн баталгааны тоо: 5</p>
<p>12 “Хоцролтгүй хамт олон болцгооё” уриатайгаар “Өглөөний сэрүүлэг” булан ажиглүүлж, ёс зүйн тухай хууль, дүрмийн талаар мэдээллийг түгээнэ.</p>	<p>7 хоногт 2 удаа мэдээлэл байршуулж хэвшсэн байна.</p>	<p>Долгоо хоног бүрийн Даваа, Баасан гарат “Өглөөний сэрүүлэг” булангаар харилцаа, хандлага, зөвлөн ур чадвар, хувь хүний хөгжил, соёлын талаар мэдээ мэдээлэл, видео шторкийг байгууллагын дотоод сүлжээгээр түгээдэг. Түгээсэн мэдээллийн тоо: 39</p> 
<p>13 “Та мэдэх үү” булангаар ёс зүйн хэм хэмжээ, танин мэдэхүйн чиглэлээр мэдээллийг түгээнэ.</p>	<p>7 хоногт 1 удаа мэдээлэл байршуулж хэвшсэн байна.</p>	<p>Долгоо хоног бүрийн Лхагва гарат “Та мэдэх үү” булангаар ёс зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж, дүрмийг сурталчлан таниулах мэдээ, мэдээллийг байгууллагын дотоод сүлжээгээр түгээдэг. Түгээсэн мэдээллийн тоо: 21</p> 
<p>14 Ажлын цаг ашиглалтыг сайжруулах чиглэлээр ирц, цаг бүртгэлийн байдалд дүн шинжилгээ хийж танилцуулсна.</p>	<p>Улирал бүр мэдээ, тайланг гаргаж, удирдлагад танилцуулсан байна.</p>	<p>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах чиглэлээр ирц, цаг бүртгэлийн мэдээг ERP E-Mongolia системээс өдөр бүр алба тус бүрээр гаргаж, мэдээлгэж байна. 1-р улирлын цаг ашиглалтын тайланг гаргаж, мэдээллийн цагаар нийт албан хаагч болон удирдлагад танилцуулсан.</p>
<p><b>4. Үйл ажиллагааны ил тод байдлын чиглэлээр</b></p>		
<p>15 Байгууллагын цахим хуудас болон нүүр хуудсанд ёс зүйн талаарх гарын авлагыг байршуулж, мэдээ мэдээллийг баяжуулсна.</p>	<p>4-өөс доошгүй мэдээ мэдээллийг бэлтгэн байршуулсан байна.</p>	<p>Төвийн Ёс зүйн хорооноос зохион байгуулсан 2 удаагийн сургалт, ярилцлагын мэдээллийг Цаг үеийн мэдээлэл цэсэнд, Ил тод- Ёс зүй цэсэнд 5 мэдээ, мэдээлэл байршуулсан. Холбогдох линк: <a href="http://hdc.gov.mn/post/1306/">http://hdc.gov.mn/post/1306/</a> <a href="http://hdc.gov.mn/post/1221/">http://hdc.gov.mn/post/1221/</a></p>

16	Мэдээллийн самбарт Ёс зүйн булган гаргаж, мэдээ мэдээлэл байршуулна.	12-оос доошгүй удаа шинэ мэдээлэл байршуулсан байна.	<a href="http://hdc.gov.mn/page/95/">http://hdc.gov.mn/page/95/</a> Төвийн үүдний мэдээллийн самбарт Ёс зүйн булган байгуулж, Хууль зүйн мэдээлэл, ёс зүйн хэмжээ, харилцаа хандлагын танин мэдэхүйн булган, санал хүсэлт илгээх QR код, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёс зүйн хэм хэмжээг уншиж танилцах QR код, Ёс зүйн дэд хорооны ажиглах журмыг уншиж танилцах QR код бүхий 4 мэдээлэл байршуулсан. Мэдээллийг 7 хоног бүр шинэчилж, солино.
17	Албан хаагчдаас ажлын байрны ёс зүй, харилцаа хандлагын талаар асуумж авч, өнгөрсөн оныхтой харьцуулж дүгнэнэ.	Дүгнэлт тайлан гарсан байна.	3-р улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
18	Албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдол, бусад материалыг хүлээн авч, хянан судалж, хэлэлцэн шийдвэрлэнэ.	Үйлчлүүлэгчдээс ирсэн гомдол, хүсэлтийг шийдвэрлэж эргэн мэдээлсэн байна.	Төвийн ёс зүйн хороонд албан хаагчтай холбоотой өргөдөл, гомдол ирээгүй байна.

Хянасан:

Б.Болдбаатар (Ёс зүйн хорооны дарга)

Боловсруулсан:

Б.Байгалмаа (Ёс зүйн хорооны нарийн бичиг)

